

БАТЛАВ
ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ц.СУГАРЖАВ

2026 оны 02 дугаар сарын 05

**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД
ХОРООНЫ 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2026.02.05.

Улаанбаатар хот

Зорилго: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, дүн шинжилгээ хийн эрсдэлийг бууруулах, алба хаагчдын харилцаа хандлагад эерэг байдлыг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлж, хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэхэд оршино.

д/д	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хугацаа	Хэрэгжилтийг хангаж ажиллах нэгж
Нэг.Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:							
1.1	Ёс зүйн дэд хорооны хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлуулж, дараалал, танилцуулга, мэдээлэл, төсөл зэргийг гишүүдэд урьдчилан хүргүүлэх.	Хуралдааны үйл ажиллагаа тодорхой байх нөхцөл хангагдана.	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	Тухай бүр	Ёс зүйн дэд хороодын нарийн бичгийн дарга
1.2	Ёс зүйн дэд хороонд сул орон тоог нөхөн бүрдүүлэх талаар хариуцсан байгууллагын Захиргааны асуудал хариуцсан нэгжид мэдэгдэж, нөхөн сонгуулж томилуулах арга хэмжээ авах.	Хүний нөөцийг шуурхай бүрдүүлж, олонхын саналаар шийдвэр гаргах нөхцөл бүрдэнэ.	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь		

1.3	Монгол Улсын Ёс зүйн хороо, бусад байгууллагатай харилцах, хамтран ажиллах.	Үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэж, хамтын ажиллагаа өргөжнө.	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	Жилдээ	Ёс зүйн хорооны дарга
1.4	Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн байгууллагын хэмжээнд нэгтгэн заагдсан хугацаанд ирүүлэх.	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	Хэрэгжилтийн хувь	92 хувь	95 хувь	06, 12 дугаарын сарын 05-ны дотор	Ёс зүйн салбар дэд хороод
Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:							
2.1.Хуулиар харьяалуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг хянан, дүгнэлт гаргах чиглэлээр							
2.1.1	Ёс зүйн дэд хороонд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хянан шалгаж, дүгнэлт гаргах.	Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	Хүлээн авсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	100 хувь	100 хувь	Тухай бүр	Ёс зүйн дэд хороод
2.1.2	Цагдаагийн төв байгууллагын удирдлага, Дотоод хяналт-аюулгүй байдлын нэгжээс харьяаллын дагуу ирүүлсэн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг хянаж, дүгнэлт гаргах.		Ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдлыг хууль, журамд нийцүүлэн хянан шалгаж, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн хувь	-	100 хувь	Тухай бүр	Ёс зүйн дэд хороо
2.1.3	Салбар дэд хорооны дүгнэлтийг эс зөвшөөрсөн, эсхүл салбар хорооны гишүүдийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гаргасан гомдлыг хянаж, дүгнэлт гаргах.		Гомдлыг хянаж шийдвэрлэсэн хэрэгжилтийн хувь	-	100 хувь		
2.1.5	Хуралдаанаас гарсан дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан		Ёс зүйн гомдол, мэдээлэл бүрд	Хэрэгжилтийн хувь	100 хувь	100 хувь	Тухай бүр

	тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих.	шийдвэр гарсан байна.					нарийн бичгийн дарга
2.1.6	Төрийн албаны цахим системд ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл, түүнийг шийдвэрлэлтийн талаар тухай бүр оруулах, гишүүдийн мэдээллийг шинэчилж байх.	Цахим бүртгэлийн үйл ажиллагаа жигдэрч, хяналт сайжирна.	Гомдол мэдээлэл, түүнийг шийдвэрлэлтийн талаар мэдээлэл оруулсан хэрэгжилтийн хувь	-	100 хувь		Ёс зүйн дэд хороодын нарийн бичгийн дарга
2.2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг сурталчлах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр							
2.2.1	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын хүний нөөц, сургалт хариуцсан нэгжтэй хамтран жилд 2-оос доошгүй удаа, шинээр ажилд томилогдсон алба хаагчид чиглүүлэх 8 цагийн сургалт зохион байгуулах.	Алба хаагчдын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн мэдлэг дээшилнэ.	Сургалт зохион байгуулсан тоо	1	5	Жилдээ	Ёс зүйн дэд хороод
2.2.2	Байгууллагад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь ганцаарчилсан болон бүлгийн сургалтыг тогтмол зохион явуулах.	Алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлага сайжирна.	Сургалт зохион байгуулсан тоо	28	30	Сар бүр	Ёс зүйн дэд хорооны гишүүд
2.2.3	Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах, сургагч багш бэлтгэх сургалтад Ёс зүйн салбар дэд хороодын гишүүд болон алба хаагчдыг хамруулах ажлыг зохион байгуулах.	Ёс зүйн дэд хороодын гишүүдийн ур чадвар дээшилж, сургалт явуулах нөхцөл бүрдэнэ.	Сургалтад хамруулсан алба хаагчдын тоо	2	10	Жилдээ	Ёс зүйн дэд хороо

2.2.4	Ёс зүйн төлөвшил, шударга байдлын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн харилцаа, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр улирал бүр контент /богино хэмжээний видео рийл, постер/ бэлтгэн байгууллагын цахим хаяг, сайт, хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан нэвтрүүлэх.	Ёс зүйн боловсролын талаарх иргэдийн мэдлэг дээшилж, харилцаа, хандлагад өөрчлөлт гарна.	Хэрэгжилтийн хувь	-	100 хувь	Улирал бүр	Ёс зүйн дэд хороод
2.2.5	Дэлхийн ёс зүйн өдрийг тохиолдуулан алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах, Ёс зүйн хорооноос зохион байгуулсан үйл ажиллагаанд нэгдэх.	Байгууллагын соёл, алба хаагчдын харилцаа, ёс зүйн байдалд эерэг хандлага бий болсон байна.	Хэрэгжилтийн хувь	-	100 хувь	10 дугаар сарын 3 дахь долоо хоног	Ёс зүйн дэд хороод
Гурав. "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд							
3.1	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дэд хорооны болон байгууллагын төлөвлөгөөнд ажил, арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх.	Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Хэрэгжилтийн хувь	-	100 хувь	06, 12 дугаарын сарын 05-ны дотор	Ёс зүйн дэд хороод
3.2	Өргөсөн тангаргаа чандлан мөрдөх сэдэл, урам зориг, дадлыг бий болгоход чиглэсэн бүтээлч ажлыг идэвхжүүлэх, соёлыг түгээх, хэвшүүлэх	Ёс зүйн эерэг соёл, уур амьсгал тогтворжсон байна.	Ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн бүтээлч үйл ажиллагаа, арга	-	100 хувь	Улирал бүр	Ёс зүйн дэд хороод

			хэмжээний хэрэгжилт				
3.3	Байгууллага төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх, байгууллага, салбарын зорилт, үйл ажиллагаа үйлчилгээний онцлогт ажиллагаа, үйлчилгээний онцлогт тулгуурласан ёс зүйн орчныг бүрдүүлэх, гаргасан ололт амжилтыг дэмжих, алдаршуулан олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх	Алба хаагчдын ёс зүйн мэдлэг, хандлага сайжирсан байна.	Арга хэмжээний тоо	-	4	Улирал бүр	Ёс зүйн дэд хороод
3.4	Томилох эрх бүхий албан тушаалтны манлайлал, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, төрийн албаны мэргэшсэн байдал, залгамж чанарыг хадгалах, хөгжүүлэх, инновац шингээсэн ёс зүйн орчин нөхцөлийг бий болгох замаар хамтын ажиллагааны үр нөлөөг сайжруулах	Хамтын ажиллагааны үр нөлөө сайжирсан байна.	Хэрэгжилтийн хувь	-	100 хувь	Улирал бүр	Ёс зүйн дэд хороод
Дөрөв.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, дүн шинжилгээ хийн эрсдэлийг бууруулах чиглэлээр							
4.1	Цагдаагийн орчин дахь ёс зүйн тандалт судалгаа хийж танилцуулах	Цагдаагийн байгууллагын ёс зүйн орчны нөхцөл байдал тодорхойлогдож, илэрсэн асуудлыг шийдвэрлэх бодитой санал, арга хэмжээ хэрэгжих үндэс бүрдсэн байна.	Танилцуулсан тоо	-	1	Жилдээ	Ёс зүйн дэд хороо ДХАБГ, СБИХА

4.2	<p>Ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөл, үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх, хариуцсан байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж, эсхүл албан хаагчид зөвлөмж хүргүүлэх.</p>	<p>Үйл ажиллагааны эрсдэл буурсан байна.</p>	<p>Зөвлөмжийн тоо</p>	<p>-</p>	<p>1</p>	<p>01 дүгээр улиралд</p>	<p>Ёс зүйн дэд хороо, ДХАБГ-ын Эрсдэл, аюулгүй байдлын хэлтэс</p>
4.3	<p>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас алба хаагчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааны талаар иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын https://police.gov.mn/ цахим хуудсанд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Ёс зүйн дэд хороо гэсэн холбоос үүсгэх, энэ чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд хүсэлт хүргүүлж шийдвэрлүүлэх.</p>	<p>Иргэд, олон нийтэд хүргэсэн мэдээллийн тоо</p>	<p>Хэрэгжилтийн хувь</p>	<p>-</p>	<p>70 хувь</p>	<p>02 дугаар улиралд</p>	<p>Ёс зүйн дэд хороо, СБИХА</p>

4 бүлгийн 21 ажил, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО

